

МОНГОЛ - ГЕРМАНЫ ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА БИДЭНД ГЕРМАНЧУУДААС СУРАХ ЗҮЙЛ БИЙ ЮУ?

Монголчууд, германчууд: “Тэд хэн бэ? Бид хэн бэ?”

Зохиолч

Чинагийн Галсан

1962 оны 8-р сарын 29-ний өглөөгүүр Зүүн Берлиний Остбаанхоф хэмээх төмөр замын төв өртөөнд бууж герман нутагт анх хөл тавьснаас хойш нэгэнт 40 жил өнгөрчээ. Энэ бол нэгэн хүний амьдралд их хугацаа. Тэгэхлээр герман болон монгол хүний төстэй хийгээд ялгарах шинж, бас бид тэднээс чухам юугий нь сурахыг эрмэлзэх хийгээд бас юугий нь суралгүй үлдээвэл зүгээр болох зэрэг хоёр улс, үндэстний хоорондын харилцааны эмзэг зарим сэдвээр өөрийнхөө ажиглаж мэдсэнийг бичиж өгнө үү гэсэн сэтгүүлийн зөвлөлийн хүсэлтийг хүлээн авахгүй байж болсонгүй. Ялангуяа герман судлалын мэргэшлээр суралцаж төгсгөсөн, хожим эрхэлсэн ажлынхаа онцлогоос шалтгаалан тэр орны улс төр, хүн ард, хэл соёлын тухайд өнгөрсөн он жилүүдэд цаг, хором биш юмаа гэхэд сар, өдөр болгон эргэцүүлж бодох учир бүрдсээр ирсний хувьд хэлбэл ч хэлэхээр зүйлс бишгүй нэг хуралджээ. Тэгэхдээ тэр бүхэн бол миний субъектив бодол таамаглал, надтай санал нийлэхгүй нэгэн байх аваас өөрийнхөөрөө хандаж, аливааг хүссэнээрээ ойлгох эрхтэй болох нь мэдээж.

Монголчууд, германчууд хоёрт төстэй хэд хэдэн чанар анзаарагддаг. Хоёул оюун болоод бие бялдрын хувьд бялтай, өрсөлдөгчийнхөө сэтгэлийнх нь хоймрыг ч эзэгнэхээр, гарынх нь шүүсийг ч хангахаар. Нялганаж нялцагнах дургүй, түс тас зантай, дайчиндуу чанартай. Үүнээсээ болоод бүдүүлэгдүү. Хэн хэн нь тэвчээртэй юм уу гэтэл тэвчээргүй, үнэхээр тэвчээргүй юм уу гэтэл баргийн зүйл дээр тэвчээд гарчих шөрмөстэй. Нэг

нь аливаад удаан, болхидуу, нөгөө нь шаламгай гялалзуурын тухайд гэвэл аж амьдралынх нь үндэс болох эрхэлсэн ажил төрөлтэй нь холбоотой. Энд уудам талд салхины исгэрээн дор мал дагасаар ухаан цэгцэрч, бие гүйцдэг бол тэнд давчуу танхимд цагийн цохилтон дор өсөлт гүйцэж, хатаалга чангардаг. Тэхдээ хэдэн зууны өмнөх герман, монгол оноогийнхөөс хавьгүй илүү хоорондоо төстэй байсан байж таарна. Учир нь германчууд ч гэсэн тухайн цаг үед өлгийнөөсөө тэгтэл холдоогүй байсан. Хүүхэд хоорондоо насанд хүрэгсдээс илүү төстэй байдаг шиг улс үндэстэн хөгжлийнхөө эхэн үед хожмынхоосоо илүү бусадтайгаа ойролцоо байдаг.

Монголчууд, германчууд хоёрыг ойртуулагч дараагийн хөрс дэвсгэр бол тэдгээрийн туулж өнгөрүүлсэн дайн дажин, ялалт ялагдлаар дүүрэн түүх юм шиг. Хэн хэнийх нь гэмгүй чийрэг бие бялдар, хэдэр догшин ааш араншин дайн тулааны талбарт хэрэг болдог байсан болов уу. Ган төмөр хуягтай ромчуудын өөдөөс нүцгэн хэнхдэг гаргачихаад дайран орж байсан эртний германчуудын тухай түүх судраас уншихад цусаа харчихаад улайран дайрагч монгол баатрын тухай домог түүх өөрийн эрхгүй санаанд ордог. Энд нэг зүйлийг тодруулахад, бидний герман гэж нэрлээд байгаа тэр хүмүүс өөрсдийгөө дойч, эх орноо дойчланд гэдэг, жинхэнэ германчууд бол өвөг үндэстэн, уугуул эх орных нь нэр билээ. Тэдгээр өвөг дээдсийнхээ үед германчуудыг монголчуудтай холбох илүү бат зузаан хөрс дэвсгэр байсан нь бөө мөргөл.

Тиймээ, энэ өнцгөөс лавлан харвал биднийг тэдэнтэй холбох зүйл нэн арвин. Монголчуудын язгуур итгэл үнэмшил нь бүхнийг амьдчилж, хөх тэнгэр эцэг, хөрст газар эхийгээ хязгаар хярхаггүй орчлон ертөнцтэй цуг дээдлэн үзэгч харын буюу бөөгийн шашин бөгөөд хожим буддын буюу шарын шашныг шүтэх замд орсон нь олон үеийн турш үргэлжилсэн даралт шахалтын үр дүн. Нарийндаа бол Монгол дахь буддын шашныг шар хуяг (бөөгийн нөмрөг) хөдөрч, цаасан ташуур далайсан бөө мөргөл гэхэд хилсдэхээргүй байдаг нь овоо

тахих, лүйжин тавих, сэржим өргөх зэрэг олон зүйлээс харагддаг. Энэ үнэн бол асар их хүчирхийлэл, аллага таллагын үр дүнд тогтсон Герман дахь загалмайн ёсыг сүм овоотой, лам зайрантай бөө мөргөл гэхэд хилсдэхээргүй нь хоёр мянганы тэртээх өвөг дээсийнх нь үзэл үнэмшил юм юманд шингэж, нуугдаж үлдсэнээс харагддаг. Соён гэгээрүүлэгчдийнх нь дийлэнх байгаль дэлхийг амьдчилж ойлгодог пантеизм хэмээн үзлийг шүтэж, бүтээл туурвилдаа түүнийгээ барим тавим харуулсаар байсныг хэлэлтэй. Гётегийн “Фауст” бол зүгээр нэг эмгэнэлт жүжиг биш, асар урт, аугаа далайцтай бөөгийн тамлага, алагтай цоогтой, амьдралтай үхэлтэй ертөнцийн зураглал юм. “Вальпургис шөнө” хэмээх үзэгдэл л гэхэд бөө ёсны ухаан учрыг урвуулж биежүүлсэн, гүн гүнзгий ёгтлол гэлтэй. Бетховены алдарт тавдугаар симфоны дүд-дүд-дүд-дүүд гэж эхлэх дөрвөл авиа нь тэр чигээр бөөгийн хэнгэргийн цохилт юм. Рембрандтын (холланд хүн л дээ, гэхдээ тэр нь өвөг Германы олон хүүхдийн нэг нь) зураг дээрх хар, цагааны харшил дундаас хорин есний шөнийн дүлий харанхуй, гал өрдсөн ган тулга хоёр эгшин зуур нүднээ харагдах шиг болдог. Энэ мэтчилэн ухаж төнхөөд байвал бөө мөргөлийн ул мөр шингэж хоцорсон зүйлс герман оюуны бүтээл, ахуйн зан заншлаас бараг алхам тутам олдоно.

Үүнийг уншсан зарим хүн германчууд өөрсдөө бөөгийн тухай ерөөс ам ангайдаггүй шүү дээ гэж гайхаж мэдэх. Тийм ээ, бөө - *der Schamane*, бөө мөргөл - *das Schamanentum* гэдэг нь герман хэлэнд саяхнаас орж ирсэн харь үгс. Гэхдээ язгуур герман үг бас байдаг нь *der Heide*, *das Heidentum* бөгөөд тэдгээрийг толь бичигт онгон шүтэгч, онгон шүтэх үзэл гэсхийгээд орхисон байх юм. Өнөө цагт манай орны сум, багийн нутаг хүрчихээд бэлэг сэлт тараан ятгалга үйлдэж яваа христос шашны миссионарууд үргэлж ийм нөхөрсөг байсангүй. Тэд өвөг германчуудыг хүйс тэмтрэн, онгод догшдыг нураан, галдан байж оронд нь загалмайтны сүм хийдийг босгож, жаяг дэглэмийг тогтоожээ. Олон зуун жил үргэлжилсэн уг гэсгээл шийтгэлийн ул мөр хэлэнд хүртэл нөлөөлсөн нь: Үгсийн утга ихэд бүдгэрчээ.

Гётегийн нэгэн ксение хэмээх шүлэгт: “Үзэн ядах зүйл минь дөрөв хийгээд нэрлэх юм бол тамхи, сармис, бясаа, †” гэсэн бөгөөд үүнээс үзвэл “хэрээс” гэдэг үгийг нэрлэхийг ч хүссэнгүй.

Ромын эзэнт гүрнийг цаанаас нь герман аймгууд, наанаас нь бидний өвөг дээдэс болох Хүннү нар довтолсоор унагасан нь чухамдаа хамтын бүтээл бөгөөд тэрээр дэлхий дахины хөгжлийн хандлагыг өөрчилжээ. Даанч тийнхүү хоршиж ажиллаад түүх бүтээснээ тухайн үед тэдний хэн хэн нь төдий л ухамсарлаагүй байж болох ч шашин шүтлэг, ахуй амьдралын хэвшил төстэй, бас түүхэнд нөлөөлөх хожмын их үйлсийнх нь зөн хаялага аль алиныг дотроос нь хатгасаар тухайн үеийн тэргүүлэгч гүрэнтэй хүч үзэхэд хүргэжээ гэлтэй.

Маргаан будлиантай байж мэдэх өнгөрсөн түүхийг орхиод өнөө цагт анхаарлаа хандуулья. Тэр цагийн эхлэл Дашдоржийн Нацагдорж нарын 30-аад монгол хүүхдийг Германд суралцуулахаар явуулсан 1927 оны үед тавигджээ. Тэдгээр багачууд, залуус анхлан мөрөөсч очсоноороо их, дээд сургуульд орж амжаагүй ч эцсийн бүлэгт чамлалтгүйг сурч ирээд эх орондоо дор дороо шамдан ажилласны үр дагавар гэвэл асар их. Гол нь тэд юм үзэж, нүд тайлжээ. Чухам энэ утгаар тэд хоцрогдлын туйлд хүрээд байсан Монгол орныг хорьдугаар зуунтай холбож өгсөн оюутан, сэхээтэн залуусын арми дунд нэн хүчирхэг, магадгүй тэргүүлэгч салаа байжээ гэж би хувьдаа боддог. Энэ утгаараа герман орон монгол оюуныг тэтгэн хөгжүүлэхэд шимтэй хөрс болохоо батлан харуулсан хэрэг.

1950-иад оны дунд үеэс монгол оюутны хоёр дахь үе БНАГУ-д суралцахаар очсоноор түүхэн нөхцлөөс шалтгаалан нэг үе тасалдсан хоёр орон, ард түмний харилцаа үргэлжлэн хөгжих үүд хаалга дэлгэгджээ. Түүнээс хэдэн жилийн хойно биднийг арвуул очиход өнөө Нацагдоржтой цуг явж байсан хүүхдүүдийн нэг –“Герман” хэмээх Доржсүрэн гуай манай

элчин сайдын яаманд ажиллаж байсан нь нэг ёсондоо биднийг цуутай өмнөх үетэй холбогч гүүр байжээ.

Тухайн үед байсан төр засаг энэ завсар нэгэнт үгүй боловч, манийг угтан авсан газар орон, хүрээлэн байсан хот, тосгон, бидний шамдан суралцсан хэл, соёл яах аргагүй герман байсан. Нэг талаар зорин очсон газрыг маань дэлхий дээр эсрэг тэсрэг хоёр бүлэглэлийн торгон зааг дээр оршигч анд нөхдийн маань улс орон гэж бидэнд ойлгуулсан үзэл суртлын хүч биз, нөгөө талаар Ардчилсан Герман хэмээх сонсголонтой нэрээр түүхэнд шингэж мөнхөрсөн төр улсын эрчимтэй хөгжлийн зурвас үе таарсан байх, ямар ч байсан шинэ орчин минь юм үзэж, нүд тайлаагүй хөдөөний хүүхэд надад диваажингаас өөрцгүй л санагдсан. Хөгжил гэж туйлдаа хүрсэн, хүмүүсийн зан ааш гэж хайлсан тугалга, соёл гэж тэдний яс маханд шингэсэн юм шиг. Багш нарын найрсаг, хичээл зүтгэлтэй гэдэг нь жигтэйхэн. Одоо бодоход, Улаанбаатар дахь зөвлөлтийн сургуулийн нэгэн ангийг дүүргэсэн, унаган орос хэл, орчин үеийн хүмүүжилтэй, дээр нь бас бүтэн зургаан жилийн турш герман хэл үзчихсэн нутаг нэгтнүүддээ чирэгдэж мэдэхээр, гадаад хэл байтугай латин цагаан толгой ч үгүй болхи толхи надтай тусгайлан ажиллаж байсан юм байх, Вольфганг Бруннер гэдэг багш байраар минь байнга ирж, үе үе үүгээр түүгээр дагуулж явна. Ингэж явахдаа мөхөөлдөс, шарсан зайдас амталж, аягалсан ус зэргийг авч өгөх нь наад захын хэрэг. Тэр ч байтугай нэг өдөр дэлгүүрт дагуулж ороод гэрийн дулаан, зөөлөн өмд, цамц авч өгч билээ. Урьд орой нь байраар ирэхэд нь дотуур хувцастайгаа даарчихсан, нусаа татаад сууж байсныг хараад өрөвдсөн нь тэр юм байх. Бидний хооронд хүний сайхан харилцаа үүсээд байсныг үүгээр хэлэх гэсэн юм.

Ерөөс тэр үед герман хүмүүс монголчууд бидэнд тун талтай байсан санагддаг. Хожим монголчуудын нэр хүнд доошилж, ханш унасан бол тэр нь бидний өөрсдөөс маань болсон хэрэг. Архи ууж, худал хэлж, хулгай хийж, захууран задгайрч, тэр ч бүү хэл хутга мэс шүүрэх нь бөмбөрцгийн аль

ч онцөгт бидний замд хориг хаалт болсоор байна бус уу? Түүнээс биш германчуудад монголчуудыг үзэн ядах яс, цусны гэмээр дотоод учир шалтгаан өчүүхэн ч байхгүй. Харин ч нааштай хандах учир байдгийг эл өгүүллийн эхэнд хэлсэн.

Немецкая точность, эсвэл немецкая аккуратность гэж оросчилж ирээд германчуудыг шагшин магтдаг маань тэдний гухай бид анхнаасаа нааштай ойлголттой байдгийн жишээ. Тиймээ, цаг баримтлах, аливаад няхуур нямбай ханддаг нь олонхи герман хүний хувьд бусад улс үндэстнээс ялгарах шинж мөн гэж хэлж болно. Гэхдээ энэ бол өнөө үед амьд сэрүүн байгаа наяд сая герман хүнд хамааруулж хэллээ гэхэд давын өмнө тэдний ахмад үеийнхнийг голлон оносон хэллэг болох бизээ. Deutsche Wertarbeit буюу герман хүний чанар чансаатай хөдөлмөр алга болж эхэллээ гэж дотроосоо халаглан ярьдаг болсон нь нууц ч, үндэслэлгүй ч хэрэг биш. Дэлхийн сүүлийн дайнд нурж сүйрсэн улс орныг өөд нь татаж, германы гайхамшиг гэдгийг бүтээн байгуулагсдын үе шувтарч, тэдгээрийн хүч хөдөлмөрийн үр шимийг өвлөгсдийн үе эхлээд явж байна. Wohlstand хэмээх элбэг дэлбэг амьдрал дунд өсч өндийсөн үеийнхнээс бид хэтэрхий ихийг хүлээх хэрэггүй юм. Залуу голдуу цөөнгүй герман хүний орон гэр нь гаднаасаа гял цал оргивч дотроо ундуй сундуй, хэлж амласан нь алдаг оногтой байгаа бол даяарчлалын эрин үед зөвхөн сайнаасаа саар нь суралцах биш, бас саар нь сайндаа халдварлах учир боломжийг зөвөөр ойлгох хэрэгтэй бизээ.

Гэтэл их савны ёроол, эсвэл хуучин бууны хугархай гэгчээр германчуудаас суралцах юм монголчуудад захаас аван бий. Davын өмнө сахилга бат. Үүнд хамаарагдахгүй салбар гэж байхгүй. Хувийн амьдрал, суудаг байшин сууц, хот хороо, гудамж зам, улс орны нүүр царай бүхэлдээ үүнтэй холбоотой. Тэндэхийн хот суурин өнгөлөг, гудамж талбай цэвэрхэн, барилга байшингийн шат хонгил цэмцгэр. Манайх ийм биш байгаа бол тэр нь Герман орон үйлдвэржсэн, хөрөнгө мөнгө ихтэй, Монголд тэр дутагдаж байгаатай бус, давын өмнө, германчууд хүмүүжсэн (хүн болтлоо боловсорч чадсан),

монголчууд тэгж чадаагүйтэй холбоотой. Үүнд эргэлзэх нэгэн байх аваас монголын захын нэгэн сум, багийн төвийг суллаад дан германчуудад, хариуд нь германы гял цал хотуудын аль нэгэн хорооллыг монголчуудад эзэмшүүлэх тухай төсөөлөөд үзэгтүн. Тэгээд жилийн дараа харвал өнөө сум, багийн төв подхийтлээ тохижиж, хотын хороолол энд тэндээсээ эвдэрч нуран, хогондоо дарагдсан байх вий.

Саяхан надад охин минь 14 жилийн өмнө герман хэлний бэлтгэл ангийн оюутан байхад нь миний Будапештээс бичсэн захидлыг өглөө. Уг захидал дотор: “Архийг амсаж, кофег ууж, тамхийг тэвчиж сур!” гэсэн эргэлзээтэй гэмээр үгс байх юм. Тэвчиж сур гэдгийн тухайд бол тамхины утаатай орчинд байж сур гэсэн нь захидлын хам утгаас ойлгогдож байна. Гадаадыг зүглэхээр бэлтгэгдэж буй үр хүүхэддээ эцэг миний тийнхүү хайрласан сургамжийн гол учир гэвэл усыг нь уувал ёсыг нь дагах тухай санаа байна.

Тиймээ, германчуудын дунд ороход бидэнд өөрт тээртэй ч дагахаас замгүй зүйлс бий. Захаас нь нэрлэвэл, хүний өөдөөс эгцлэн харж сурах. Мишээж сурах. Талархсанаа илэрхийлж сурах. (Зарим айлд байдагчлан нэг удаа ширээнд сууж хоол идээд босохдоо хорь, гучин удаа *danke* гэж хэлэх шаардлагагүй байж болно, гэхдээ эгзэгийг нь тааруулж байгаад баярлаж талархсанаа нэг ч болов удаа хэлээд авахгүй бол тэдэнд нэг л юм дутуу санагдана.) Айл хунар, хүн амьтантай харилцаатай байдаг бол хэн нэгнийх нь төрсөн өдрөөр ч юмуу ядахдаа жилдээ нэг удаа бүлээн зөөлөн үгстэй захиа бичиж, бултад мэнд хүргэхийг мартажгүй байх. Дэргэд нь хог хаях, адгуус амьтныг зодох, тамлах, хүүхэд зандрэхыг тэвчих....

Энэ мэтчилэн герман хүнээс монгол хүн сурах зүйл захаас аван, замаар нэг байхад сурах хэрэггүй зүйл ч цөөнгүй. Үүнд, хувиа хичээх үзлийг бүхний түрүүнд хэлмээр байна. Эд мөнгөний тухай яриа. Гүн ухаан, урлаг, улс төрийн мэдлэгтэйгээ харуулахаар хий цэцэрхэх. Хүүхдээ магтах. Эх, эцгийнхээ тухай дурсахгүй хэрнээ муур, нохойн тухай яриа дэлгэх.

Товчхондоо, тэднээс бид хөдөлмөрийн хийгээд ахуйн соёл, ариун цэвэр, байгалийн салбар шинжлэх ухааны гадархай мэдлэг, техниктэй харьцах чадвар, жишээ нь, машин жолоодох, түүнийг зогсоолд тавих, ингэхдээ аль алинд нь бусдад тээр саад болохгүйг бүхний түрүүнд анхаарах зэргийг сурмаар байхад тэд биднээс эх, эцгээ хийгээд эх дэлхийгээ дээдлэн хүндэтгэх соёлыг сураасай гэмээр санагддаг.

Монгол, Герман хоёр хоорондоо хол оршивч монголчууд, германчуудын нэг нэгийгээ гэх сонирхол нь их юм. Азийн бөглүү хээр талд орших хоёрхон сая гаруй монголчуудын дундаас гурван түм орчим хүн тэр ард түмний хэлээр ярьж байгаа нь дэлхийн чихийг дэлдййлгэмээр баримт мөн. Европын төвд оршигч, чухамдаа тэр тивийн ноён нуруу гэмээр хүчирхэг Герман улс одой дорой эдийн засагтай манай орныг голж чамлалгүй түншилсээр, ингэхдээ байн байн тусламжийн өгөөмөр гараа сунгасаар байгаа нь ч бас нарийн учир жанцантай.

Мөнхийн үнэ цэнэтэй баялаг гэвэл газар нутаг. Орчин үед үнэ цэнэ нь өссөөр байгаа баялаг гэвэл боловсрол. Энэхүү хоёр төрлийн баялагийг нөхцөлдүүлж чадах аваас ихээхэн үр дүнд хүрэх нь мэдээж. Үүнд хөдөлгүүр хэрэгтэй. Тэрхүү хөдөлгүүр нь мөн байж болох субъектив хүчин зүйл хоёр ард түмний хооронд бий гэдгийг өгүүллийнхээ эхний хэсэгт гаргахыг оролдсон.

Дөчин жилийн өмнө германы газар шороон дээр анх хол тавихдаа өрнөдийн соёлын талаар дөр ч үгүй сохор гөлөг шиг амьтан байжээ. Эл өгүүллийг тэрлээд дуусч байсан энэ мөчид герман хэлээр бичсэн 18 дахь ном минь уншигчдын 9 захиа дагуулсаар гэрт минь орж ирлээ. Өөрийн биеэр туулж өнгөрүүлсэн амьдрал минь герман орон монгол оюуныг тэтгэн хөгжүүлэх шимтэй хөрс болох тухай итгэлтэй хэлэх эрхийг налад олгож байна.